

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.-ийн “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.7-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 25/21 дүгээр тогтоолын дагуу Нийслэлийн Налайх дүүрэгт 1, Сонгинохайрхан дүүрэгт 11, Хан-Уул дүүрэгт 5 нийт 17 хороо шинээр байгуулагдсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

## Ажлын хэсгийн

- |         |  |
|---------|--|
| дарга   | -Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан                     |
| Гишүүд: | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга<br>Э.Содномжамц;  |
|         | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд;                    |
|         | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүү;                           |
|         | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А.Даваажаргал;                             |
|         | -Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга А.Энхманлай;  |
|         | -Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Б.Ууганбаяр;   |
|         | -Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга О.Чинзориг;   |
|         | -Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Г.Цэцгээ /зөвшилцсөнөөр/; |

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ /зөвшилцсөнөөр/.

Нарийн бичгийн

дарга

-Нийслэлийн Бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр.

2.Шинээр байгуулагдсан хороодын иргэдийн хаягийн өөрчлөлттэй холбоотой саналаа 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор боловсруулж, танилцуулахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН